

## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

№ 23/01

Улаанбаатар хот

### Бүрэн эрхт төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.13 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.8, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, 83 дугаар зүйлийн 83.8 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.1, 9.6.5 дахь заалт, 9.11 дэх хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 22/17 тоот тогтоолын дагуу Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан “ЛэндМН Актив ТЗК” ХХК (цаашид “Охин компани”)-д Компанийн эзэмшиж буй хувьцааны эрх буюу хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх бүрэн эрхт төлөөлөгчөөр Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-ыг томилсугай.
2. Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
3. Охин компанийн гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотой аливаа үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Охин компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилт, Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж буйтай холбоотой аливаа шийдвэр, үйл ажиллагааг Компанийн ТУЗ-д тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
5. Компанийн ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 22/17 тоот тогтоолын дагуу Б.Удвалд олгосон байсан бүрэн эрхийг энэхүү тогтоол гарсан өдрөөс эхлэн дуусгавар болгосугай.



О.БОЛДБААТАР

## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

№ 23/02

Улаанбаатар хот

### Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, 9.11 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 669 тоот тогтоол болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 669 тоот тогтоолоор банк бус санхүүгийн байгууллагуудын “Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх” тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан Компани нь уг тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг цаашид эрхлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан Компанийн зүгээс “Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх” тусгай зөвшөөрлийн дагуу энэхүү тогтоол батлагдсан өдрийн байдлаар харилцагчтай байгуулсан аливаа гэрээ, хэлцэл байхгүй, харилцагчийн өмнө үүрэг хүлээгээгүй болохыг тэмдэглэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмээс “Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх” тусгай зөвшөөрлийг хасах буюу Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулан шийдвэрлүүлэхээр тогтоосугай.
4. Энэхүү тогтоолыг Компанийн үйл ажиллагаанд мөрдөх, Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



О.БОЛДБААТАР

## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

№ 23/03

Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны жилийн эцсийн хурлын товыг өөрчлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.8 дэх хэсэг, 9.11 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 22/09 тоот тогтоол болон Компанийн ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2022 оны жилийн эцсийн хурлын товыг 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байхаар шинэчлэн тогтоосугай.
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 22/09 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан хуваарийн холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.
3. Энэхүү тогтоолын 1-т заасны дагуу Компанийн ТУЗ-ийн 2022 оны жилийн эцсийн хурлыг 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хуралдуулах бэлтгэл ажлыг зохион байгуулахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д, түүнд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-д тус тус үүрэг болгосугай.



# “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

№ 23/04

Улаанбаатар хот

## Гүйцэтгэх захирлын Репо арилжаанд оролцох эрхийг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.22, 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 22/12 тоот тогтоол, 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 22/26 тоот тогтоол болон Компанийн ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн эх үүсвэрийг үр ашигтай удирдах зорилгоор Репо арилжаанд зээлдэгч болон зээлдүүлэгчийн хувиар оролцоход баримтлах арилжааны хэмжээг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолоор шинэчлэгдсэн батлагдсан арилжааны хэмжээний дагуу Репо арилжаанд оролцох, арилжааны хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан Компанийн хэвийн зээлийн багцыг нэмэгдүүлсэн хэмжээнээс тооцон нэмж барьцаалах, эдгээр үйл ажиллагааны хүрээнд “Мони Маркет Фанд” ХХК-тай нэмэлт гэрээ, хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Репо арилжаанд Компанийн эрх ашиг болон дотоод бодлогод нийцүүлэн оновчтой оролцох, үр ашигтай түвшинд удирдан зохион байгуулж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Компанийн ТУЗ-д тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

О.БОЛДБААТАР